

“АХМАДЫН ХОТХОН-1” ОНӨААТҮГ-ААС САР ШИНИЙН БАЯРЫГ УГТАЖ БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААРХ АЖЛЫН МЭДЭЭ

2018.02.14

Улаанбаатар хот:

Нэг. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ:

Тус хотхоны ашиглалт үйлчилгээг хариуцаж буй 901,902 дугаар байр, түр оршин суух 813 дугаар байрны гадна талбай дахь нийтийн эзэмшлийн 850м² зам талбайд тогтсон цас, мөсийг цэвэрлэх ажлыг 2018 оны 02 сарын 09,11–ны өдрүүдэд зохион байгуулж нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр явган хүний болон авто зам дагуух мөстсөн зам талбайг цэвэрлэж иргэд, явган зорчигчийн зорчих хэсгийн халтиргаа гулгааг арилгах зам гарцаар эрсдэлгүй зорчих нөхцлийг хангууллаа.



Хоёр. Хотхоны 901,902, 813 дугаар байруудыг иргэд оршин

суугчдын оролцоотойгоор нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулсан талаар:

Тус хотхоны захиргаанаас 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдөр оршин суугч иргэдэд их цэвэрлэгээ хийх зарлал хүргүүлж 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 11⁰⁰-15⁰⁰ цагийн хооронд дундын эзэмшлийн хана туурга, хаалгаа угааж цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулж, байгууллагын нийт 18 ажилтанд 901,902,813 дугаар байруудын шатны хөндий, болон цахилгаан хуваарилах самбар, лифт орчмын хана, цонхуудыг угаах нэгдсэн хуваарь гаргаж нийт 3274м² талбай бүхий хана, шатны хөндийг угааж цэвэрлэн, коридорт 52 ширхэг лед гэрэл шинээр суурилуулж, орцны гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, өнгө үзэмжийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.



*Гурав. Хогийн цэгт хог хаягдлын хуримтлал бий болгохоос
урьдчилан сэргийлэх чиглэлээр:*

Ахмадын хотхоны 901, 902, түр оршин суух 813 дугаар байрны хогийн цэг дэх хог хаягдлыг ачуулах арга хэмжээг Сүхбаатар дэвшил ХХК-тай хийгдсэн гэрээний дагуу 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулж нийт 40 тн хогийг ачуулах арга хэмжээг зохион байгуулж хур хог хаягдлын хуримтлал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, цаашид сар шинийн өдрүүдэд оршин суугчдын хуурай хог хаягдлыг зөөвөрлөн асгах арга хэмжээг 2018 оны 02 сарын 14, 16-ны өдрүүдэд зөөвөрлүүлэхээр хүсэлтээ Сүхбаатар дэвшил ХХК-ний орлогын байцаагч, жолооч нартай тохиролцож сар шинийн баяр амралтын өдрүүдэд хариуцлагатай эргүүл жижүүрээр ажиллах бүрэлдэхүүнд хог хаягдлын хуримтлал үүсэх болон хог шатахаас урьдчилан сэргийлж ажиллах талаар үүрэг, даалгавар өгч ажиллаж байна.



“АХМАДЫН ХОТХОН-1” ОНӨААТҮГАЗАР